



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/143

Улаан-Уул

Шар усны үерээс урьдчилан сэргийлэх  
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан “Шар усны үерийн аюулаас урьдчилсан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/188 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд нийт нутгаар цас ихтэй уулархаг газар, гуу, жалга, гол, нуурын цас, мөс хайлж шар усны үер буух аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 04 сарын 13-ны өдрөөс 2022 оны 04 сарын 28-ны өдөр хүртэл 14 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Цаг агаарын мэдээг иргэдэд багц мессежээр олон давтамжтайгаар шуурхай хүргэх, гол, нуур, арал, тохой, эрэг дагууд болон уулын ам, бэл, гуу, жалга сувгийн ойролцоо айл өрхүүдийг бууж суурьшихгүй байхыг анхааруулах, цасан бүрхүүл болон гол нууруудын мөсний зузаан зэрэг мэдээллийг сумын Онцгой комисст хүргүүлж ажиллахыг багуудын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж хэрэгжилтийг ханган тогтоосон хугацаанд биелэлтийг гарган аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



• 642201061